



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2008 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасныг үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ НЬ :

Нэг. "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчийн уг тэтгэврийг авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагчийн төлбөл зохих хувиар тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд төлж байхаар тогтоосугай.

Хоёр. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас төлсөн шимтгэлийг бүртгэх, тайлагнах, зарцуулалтад нь хяналт тавихад баримтлах журам баталж мөрдөхийг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар /Ч. Алтанхуяг/-т даалгасугай.

Гурав. Уг тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын алба /М. Батаа/-д даалгасугай.



ДАРГА

С.ЧИНЗОРИГ